



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн  
захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр  
дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Өлгий хот

2017 оны 04 дүгээр сар

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	4
2	Аудитын тайлан .....	6
2.1	Оршил	6
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	7
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	8
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	10
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	11
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	11
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	
2.11	Санхүүгийн таайлангийн үзүүлэлтүүдийн талаарх тайлбар тодруулга	12
2.12	Шилэн дансны мэдээлэл <b>Error! Bookmark not defined.</b>	
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга <b>Error! Bookmark not defined.</b>	
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл <b>Error! Bookmark not defined.</b>	
3	Менежментийн захидал.....	36
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл <b>Error! Bookmark not defined.</b>	
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	<b>Error! Bookmark not defined.</b>
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	<b>Error! Bookmark not defined.</b>
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	<b>Error! Bookmark not defined.</b>
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	<b>Error! Bookmark not defined.</b>

## Товчилсон үгийн жагсаалт

АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ААН	Аж ахуйн нэгж
АТӨЯХ	Авто тээврийн өөрөө явагч хэрэгсэл
БХС	Байгаль хамгаалах сан
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНС	Засаг даргын нөөцийн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХС	Мал хамгаалах сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОН	Орон нутаг
ОНӨААТҮГ	ОН-ийнөмчтэй аж ахуйн төсөвт үйлдвэрийн газар
ОНӨҮГ	ОН-ийнөмчтэй үйлдвэрийн газар
ОНХО	ОН-ийнхөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийг хөгжүүлэх сан
СНТ	Санхүүгийн нэгтгэсэн тайлан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭХЭМДС	Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих сан
БОХНС	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх сан

## 1 Аудитын гэрчилгээ

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
А.ГЫЛЫМХАН ТАНАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН

АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий сум, Баян-Өлгий аймаг,  
Утас/факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2017.04.21 №57/04-2017/147-767  
таний -ны №-т

Г

Аудитын гэрчилгээ

7

Аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккруул сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Терийн аудитын тухай хуулийн 15.2.3-т заасан бүрэн эрхийн дагуу аудит хийв.

Аймгийн Засаг дарга нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлзэнэ.

Терийн аудитын байгууллага нь Аймгийн Засаг даргын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлзэнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл.**

Терийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материалын буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Аймгийн Засаг даргын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дун хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хетлэлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдэлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохицой үндэслэлийг бүрдүүлсэн.

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах алдаа зөрүүнүүд нь Оршин байх, Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Нийт хөрөнгө, ер төлбөр/цэвэр хөрөнгийн эцсийн үлдэгдэл аудитлагдсан дүнгээс 50,8 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн.
- Үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн аудитлагдсан дүнгээс 20,200.6 сая төгрөгөөр, Мөнгөн гүйлгээний нийт орлогын дүн 20,072.1 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлэгдсэн.
- Үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн аудитлагдсан дүнгээс 19,829.5 сая төгрөгөөр илүү, үр дүн 11.7 сая төгрөгөөр зөрүүтэй, мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлагын дүн аудитлагдсан дүнгээс 19,213.5 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрхи зөрүүнүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх нелөөллийг эс тооцвол Аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН



## Нэг. Ерөнхий зүйл

### 2 Аудитын тайлан

#### 2.1 Оршил

Баян-Өлгий аймгийн Засаг дарга А.Гылымхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц запруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дунд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

#### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийллээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль,

тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэл тайлан нь иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт бөгөөд хамарсан асуудлууд болно.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх” гэж заасан боловч ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Аймгийн аудитын газарт 4 дүгээр сарын 10-ны өдөр 1-01/597 дугаар албан бичгийн дагуу ирүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 4 дүгээр сарын 01-нээс 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 4 дүгээр сарын 21-нд Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Аймгийн аудитын газрын санхүүгийн аудитын баг хэрэгжүүлэв.

## 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв. Ингэхдээ санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болголоо.

## 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баян-Өлгий аймгийн Засаг дарга “Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төрийн бодлогыг аймгийнхаа онцлогт тохицуулан боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэх өндөр чадавхтай, зөв зохион байгуулалттай, хариуцлагатай

удирдлагын тогтолцоог бүрдүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг шинэ шатанд гаргаж, ард иргэдийнхээ амьдрах орчинг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлнэ” гэсэн эрхэм зорилгын дор Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Баян-Өлгий аймгийн Засаг дарга нь холбогдох хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Баян-Өлгий аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт: -Эдийн засгийн хөгжлийн бодлого, Дэд бүтцийн салбарын хөгжлийн бодлого, Нийгмийн хөгжлийн бодлого, Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого, Засаглалын бодлогод нийцүүлэн тус бүр 1-6 эрхэм зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Баян-Өлгий аймгийн Засаг дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бodoх бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн
- Шилэн дансны тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж эрхийн актууд

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## 2.5 Нягтлан бodoх бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал”-ыг баримтлан, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 5.1, 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бodoх бүртгэлийн аккруэль суурийг хэрэглэж, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж гаргасан байна.

Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэгтгэлийг энэ жилийн хувьд анх удаа Засгийн газрын Е-тайлан цахим системд байгууллагуудын шивж оруулсан санхүүгийн тайланг системээс татаж нэгтгэх замаар нэгтгэн гаргасан байна.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.4-д заасан хугацаанаас 10 хоногоор хугацаа хожимдуулж ирүүлсэний дээр байгууллагын төрлөөрх тайлангийн нэгтгэлийг салбараар нь зөв ангилж гаргаж ирүүлээгүй, төсөвт байгууллагуудын е-тайланда шивсэн тайланг сумын санхүүгийн алба болон ерөнхий санхүүч аудитлагдсан тайлантай тулгаж хянан баталгаажуулаагүй, зарим байгууллагууд аудитлагдаагүй санхүүгийн тайланг е-тайланда оруулсан, зарим байгууллагуудын төсвийн төлөвлөгөөг нь е-тайланда суулгаагүй байсан зэргээс шалтгаалж ТЕЗ-ийн СНТайлан зөрүүтэй нэгтгэгдэж аудитын ажлыг хүндрүүлсэнийг зориуд дурьдах нь зүйтэй байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч нь 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдөр шинээр томилогдсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд харьяа төсөвт байгууллага, төрийн сан, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөл, сангувудын санхүүгийн тайланг хамруулжээ.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй:

A. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
ТЕЗ-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим
ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	Толилуулгын суурь
ТЕЗ-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
ТЕЗ-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Бид санхүүгийн нэгтгэсэн тайландаа материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Бид санхүүгийн тайландаа материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн тухай хуулийн 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх” гэж заасныг баримтлан 2014 оноос эхлэн Засаг даргын дэргэд дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн хяналт, дотоод аудитын албыг байгуулан ажиллуулж ирсэн байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2016 онд “Эрсдэлд сууринсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, олон нийтийг эрсдэлээс хамгаалах, зөвлөн туслах үр нөлөөтэй механизмыг бий болгож, төсөвт байгууллагуудын дотоодын хяналтын тогтолцоог төлөвшүүлэх” зорилт дэвшүүлэн ажилласан байна.

2016 онд 112 нэгжид шалгалт хийхээр төлөвлөснөөс 51 төсөвт байгууллагад төлөвлөгөөт шалгалт хийж, дээд байгууллагын шийдвэрээр 1, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр 20, иргэдийн гомдолоор 12 шалгалт хийж, шалгалтаар нийтдээ 73,2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 29,3 сая төгрөгийг барагдуулсан байна.

Шалгалт хийсэн байгууллагуудад Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад журам, зааварын талаар зөвлөгөө өгч эрсдэлээс урьдчилан сэргийлэх, батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулах, өр, авлага үүсгэхгүй байх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд шалгалтыг чиглүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахад анхаарч ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж 112 байгууллагын хамруулж, шилэн дансны хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд хүргүүлж ажилласан байна. Аймгийн аудитын газраас шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн 2 удаагийн аудитар өгсөн зөвлөмж, албан шаардлага, хариуцлага тооцуулах саналын хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгч ажиллажээ.

## 2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Баян-Өлгий аймгийн Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуульяа.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 18 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд эрсдэл өндөр асуудал гараагүй, 16 асуудал эрсдэл дунд үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 48 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй асуудлуудыг тодорхойлон аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг

сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

## 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад бага дүнтэй байсантай холбоотой юм.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 83520,0 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 835,3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэлийн үнэлгээ, дотоод хяналтын үнэлгээний түвшинтэй холбоотой юм.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 7 чиглэлээр 18 эрсдэлтэй асуудалд 18 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад запруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, запруулах боломжтой асуудал буюу запруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

ТЕЗ-ийн СНТайлангийн хувьд аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, тулгалтын дараа аудитлагдсан тайлан хооронд дараах зөрүүнүүд гарсан байна. Үүнд:

- Нийт хөрөнгө, өр төлбөр/цэвэр хөрөнгийн эцсийн үлдэгдэл аудитлагдсан дүнгээс 50,8 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн.
- Үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн аудитлагдсан дүнгээс 20200,6 сая төгрөгөөр, Мөнгөн гүйлгээний нийт орлогын дүн 20072,1 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлэгдсэн.
  - Үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн аудитлагдсан дүнгээс 19829,5 сая төгрөгөөр илүү, үр дүн 11,7 сая төгрөгөөр зөрүүтэй, мөнгөн гүйлгээний

тайлангийн нийт зарлагын дүн аудитлагдсан дүнгээс 19213,5 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна.

## 2.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргалт, е-тайлан программын нэгтгэл, тайлагналын асуудал
- Төсвийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагуудын жилийн эцсийн санхүүгийн тайланг е-тайлан программд оруулсан байдал, хянаж баталгаажуулалтын асуудал

### Хоёр. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу явуулахаас гадна ТЕЗ-ийн хэмжээнд хяналт тавьж ажиллахаар заасан.

2016 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, хуулийн дагуу оруулах ёстай бусад мэдээллүүдийг [www.shilendans.mn](http://www.shilendans.mn) цахим хуудсанд байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитын явцад болон нийцлийн аудитаар шалгасан дүнгээс үзэхэд шилэн дансны тухай хуулийн дагуу 2016 онд ТЕЗ-ийн харьяа орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагууд бүрэн хамрагдсан байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудитаар шилэн дансны цахим хуудсанд тавих ёстай мэдээллэлийг бүрэн оруулаагүй байгууллагуудад зөрчил дутагдлыг арилгуулах албан шаардлага өгч хэрэгжилтэйг нь хангулсан байна.

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР ТОДРУУЛГА

### Гурав. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

#### 3.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- ОН-ийн төрийн сангийн дансны үлдэгдэл, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан, харилцах дансдын үлдэгдэл, ОНӨҮГ-үүд, төсөл сангийн төгрөгийн харилцах дансдын үлдэгдэл
- Кассад байгаа бэлэн мөнгө.

ОН-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2869,5 сая төгрөг байснаас 29,1 хувиар буурч, 2035,1 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 99,5 хувь буюу 2025,0 сая төгрөг нь банкинд байршиж байгаа мөнгө байна.

ОН-ийн төсвийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2016 оны үлдэгдлийг бүтцийг байгууллагын төрлөөр харуулбал:

(сая/ төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс
Кассад байгаа бэлэн мөнгө	6.8	10,0	10,0		
Төгрөг/ЖМС	6.8	10,0	10,0		
Банкинд байгаа бэлэн мөнгө	2,862.7	2025,1		464,2	1560,9
Төгрөг	2,862.7	2025,1		464,2	1560,9
<b>Нийт мөнгөн хөрөнгийн дүн</b>	<b>2,869.5</b>	<b>2035,1</b>		<b>464,2</b>	<b>1560,9</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:</b>					
Төрийн сан	2,223.70	1010.3			1010.3
Төсөвт байгууллагууд	235.9	508.4	0.8	33.4	474.2
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	299.3	421.9	9.3	412.6	
Төсөл, сангүүд	110.6	94.5		18.1	76.4

Оны эхний үлдэгдэлтэй харьцуулбал, нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эхнээс 834,4 сая төгрөгөөр буурсны дотор, төсөвт байгууллагуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 272,5 сая төгрөгөөр, ОНӨҮГ-ын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 122,6 сая төгрөгөөр өсч, төсөл сангүүдийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 16,1 сая төгрөгөөр төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1213,4 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Төрийн сан дахь 1560,8 сая төгрөгийн 667,7 сая төгрөг нь аймгийн төсвийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл, 336,4 сая төгрөг нь сумдын төсвийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл, 44,7 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл, 180,8 сая төгрөг аймгийн ОНХСангийн, 249,1 сая төгрөг нь сумын ОНХСангийн, 44,3 сая төгрөг нь Замын сангийн үлдэгдэл, 2,1 сая төгрөг нь эх хүүхдийн дэмжих сангийн үлдэгдэл, 12,7 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтээс татан төвлөрүүлсэн орлого, 23,0 сая төгрөг нь БОХНС-ийн барьцааны үлдэгдэл байна.

### 3.2 Банкин дахь ОН-ийн харилцах дансны талаар

Арилжааны банкинд нийт 465,0 сая төгрөг байршиж байгаагийн 34,3 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын, 22,0 сая төгрөг нь бусад байгууллага, төсөл сангүүдийн, 408,7 сая төгрөг нь ОНӨААН-ийн харилцах дансны үлдэгдэл байна. Тухайлбал: мөнгөний үлдэгдлийн 32,9 сая төгрөг нь орон нутгин төсөвт байгууллагуудын, 0,5 сая төгрөг нь сургуулиудын, 0,6 сая төгрөг нь цэцэрлэгүүдийн, 0,2 сая төгрөг нь хүн эмнэлгүүдийн, 4,4 сая төгрөг нь сумдын эргэлийн эмийн сангүүдийн, 405,9 сая төгрөг нь ЦШС-ний газрын, 2,2 сая төгрөг нь “Суат” ХХК-ны, 0,6 сая төгрөг нь “Сансар” эмнэлгийн, 17,7 сая төгрөг нь бусад байгууллага, сангүүдийн үлдэгдэл байна.

## Дөрөв. Авлагын бүртгэл, тайлагнал

### 4.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт авлага оны эцэст 5146,0 сая төгрөгт хүрч оны эхнээс 229,1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Сумдын ОНХСангийн татаас санхүүжилтийн авлага 196,9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

*Нийт авлагын үлдэгдлийг бүтцээр нь харуулбал:*

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	(сая төгрөгөөр) Хувиар
Ажиллагчидтай холбогдсон авлага	10.1	21.9	11.8	216.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	37.5	133.6	96.1	356.3
Татаас, санхүүжилтийн авлага	2.5	187.5	185	7500.0
Зээлийн хүүгийн авлага	0	10.9	10.9	
Дансны авлага /ТӨҮГ/		339.5	339.5	
Татвар, НДШ /ТӨҮГ/		2.3	2.3	
Байгууллагаас авах авлага	416	109.9	-306.1	26.4
Хувь хүмүүсээс авах авлага	46.9	1054.7	1007.8	2248.8
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	250.4	250.4	0	100.0
Хувь хүмүүст СХСангаас олгосон зээл	4,153.50	3035.3	-1118.2	73.1
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4,916.90</b>	<b>5,146.00</b>	<b>229.1</b>	<b>104.7</b>

Авлагыг бүтцээр нь авч үзвэл: ажиллагсадтай холбоотой авлага 11,8 сая төгрөгөөр, төлбөртэй үйлчилгээний авлага 96.1 сая төгрөгөөр, татаас санхүүжилтийн авлага 185,1 сая төгрөгөөр, зээлийн хүүгийн авлага 10,8 сая төгрөгөөр, татвар, дансны авлага 339.5 сая төгрөгөөр, НДШ-ийн авлага 2,3 сая төгрөгөөр, хувь хүмүүсээс авах авлага 1007,8 сая төгрөгөөр нэмэгдэж, байгууллагаас авах авлага 306.1 сая төгрөгөөр, сум хөгжүүлэх сангийн авлага 1118.2 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна..

ТТЗ-ийн нэгдсэн тайлангаар зарим сумдын урьд жилийн сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл нь бодит дүнгээс зөрүүтэй тусгагдсныг авлагын үлдэгдлээс залруулж тайлагнасан нь авлагын үлдэгдэл буурч харагдахад нөлөөлсөн байна.

Авлагын үлдэгдлийг салбараар ангилж харуулбал дараах байдалтай байна.Үүнд:

авлагын нийт дүн	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	зөрүү	(сая төгрөгөөр) хувиар
Төрийн сан	250.40	250.40	-	100.00
Орон нутгийн өмчийн үйлдвэрийн газар	388.50	512.60	124.10	131.94
Төсөвт байгууллага	124.50	317.70	193.20	255.18
Төсөл сангүүд	4,153.50	4,065.30	(88.20)	97.88
<b>Нийт дүн</b>	<b>4,916.90</b>	<b>5,146.00</b>	<b>229.10</b>	<b>104.66</b>

Орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрын авлага 124,1 сая төгрөгөөр, төсөвт байгуулагуудын авлага 193,2 сая төгрөгөөр нэмэгдэж, төсөл сангүүдийн авлага 88,2 сая төгрөгөөр буурсан байна.

Төсөвт байгууллагуудын авлагатай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн.Үүнд:

- ОНӨГазрын Хөгжлийн сангийн тайланд 54.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна.
- Биеийн тамир спортын хорооны газар 1,2 сая төгрөгийн, Өлгий сумын 15 дугаар цэцэрлэг 0,5 сая төгрөгийн ХХОАТ-ын авлагыг, Ногооннуур сумын бүрэн дунд сургууль НДШ-ийн 4,2 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй.
- Ногооннуур сумын ЗДТГазар он дамжсан 6,3 сая төгрөгийн авлагыг аудитын зөвлөмжийн дагуу барагдуулаагүй.
- Эрдэм бага сургууль, Улаанхад бага сургууль, Өлгий сумын Эрдэм, 7, 8-р хүүхдийн цэцэрлэг зэрэг байгууллагууд суутгаагүй урьдчилгаа, цалинг бүгд 3,2 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаж харуулаагүй байсныг нөхөн төлүүлэхээр акт тогтоосон.
- Сумдын ТТЗ-ийн СНТайланд сумын ОНХСангийн 2016 оны батлагдсан төсөвт аймгийн ОНХСангийн төсвөөс нийтдээ 196,9 сая төгрөгийн орлогын шилжүүлэгийг санхүүгийн тайланд санхүүжилтийн авлагаар тусгаж харуулаагүй орхигдуулж Төсвийн тухай хуулийн 26.1 "Төсвийн байгууллага нь НББОУС болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтлөнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжийн урьдчилж гарсан зардал оны эцэст 36,2 сая төгрөг болж, оны эхнээс 139,6 сая төгрөгөөр буурсан байна.

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
<b>УРЬДЧИЛГАА</b>	175.8	36.2	-139.6	20.6
Урьдчилж гарсан зардал	175.8	36.2	-139.6	20.6

Энэ нь "Суат" ХХК-ны санхүүжилт нь орж ирээгүй байхад төслийн хөрөнгөөр хийсэн ажлын өртгийг санхүүгийн тайланд урьдчилж гарсан зардлаар бүртгэж, орсон санхүүжилтийн хэмжээгээр бууруулж тайлагнасантай холбоотой байна.

### Тав.Бараа материалын бүртгэл, тайлагнал

#### 5.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Бараа материалын эхний үлдэгдэл 3,240.3 сая төгрөг байсан ба оны эцэст 3,510,1 сая төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй гарч, оны эхнээс 269,8 сая төгрөгөөр өссөн байна.

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	(сая.төгрөгөөр) Хувиар
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	3,240.30	3,510.10	269.80	108.3
Түүхий эд материал	122.2	138.1	<b>15.90</b>	113.0
Дуусаагүй үйлдвэрлэл	9.9	19.2	<b>9.30</b>	193.9
Бэлэн бүтээгдэхүүн	40.1	55.9	<b>15.80</b>	139.4
Хангамжийн материал	2,736.60	2,990.00	<b>253.40</b>	109.3
биологийн хөрөнгө		9.10	<b>9.10</b>	
Мал амьтад	331.5	297.8	<b>-33.70</b>	89.8
Нөөцийн бараа	4,9	2.5	<b>-2.40</b>	
<b>НИЙТ ДҮН</b>	<b>3245,2</b>	<b>3512.6</b>	<b>267.40</b>	<b>108.2</b>

Түүхий эд материал 15,9 сая төгрөгөөр, дусаагүй үйлдвэрлэлийг үлдэгдэл 9,3 сая төгрөгөөр, бэлэн бүтээгдэхүүн 15,8 сая төгрөгөөр, хангамжийн материал 253,4 сая

төгрөгөөр, биологийн хөрөнгө 9,1 сая төгрөгөөр өсч, мал амьтад 33,7 сая төгрөгөөр, нөөцийн бараа 2,4 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт бараа материалын үлдэгдэлд түүхий эд материал 138,1 сая төгрөг буюу 4,0 хувийг, дусаагүй үйлдвэрлэл 19,2 сая төгрөг буюу 0,5 хувийг, бэлэн бүтээгдэхүүн 55,9 сая төгрөг буюу 1,6 хувийг, хангамжийн материал 2990,0 сая төгрөг буюу 85,2 хувийг, биологийн хөрөнгө 9,1 сая төгрөг буюу 0,3 хувийг, мал амьтад 297,8 сая төгрөг буюу 8,5 хувийг тус эзлэж байна.

Оны эцсийн бараа материалын үлдэгдлийн 3253,8 сая төгрөг буюу 92,7 хувь нь төсвийн байгууллагын, 256,3 сая төгрөг буюу 7,3 хувь нь орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үлдэгдэл байна.

## 5.2 Төсөл, сангийн бараа материал дансны талаар

Төсөл санд оны эцэст бараа материалын үлдэгдэлгүй байна.

## 5.3 ОНӨҮГ-ын бараа материал дансны талаар

ОНӨААН-үүдийн бараа материалын жилийн эцсийн үлдэгдэл 256.3 сая төгрөг байгаагаас Цахилгаан шугам сүлжээний газар 92.1 сая төгрөг буюу 35.9 хувийг, "Суат" ХХК 81.8 сая төгрөгийг буюу 31.9 хувийг, "Сансар" эмнэлэг 66,0 сая төгрөг буюу 25,8 хувийг, "Хала өркени" ОНӨӨҮГазар нь 0,2 сая төгрөгийг буюу 0,07 хувийг, "Жана Өлкө" ОНӨААТҮГазрын бараа материал нь 0,3 хувийг, Эргэлтийн эмийн сан 15,3 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй буюу 6,0 хувийг эзэлж байна.

Өмнөх онтой харьцуулахад "Суат" ХХК-ны бараа материалын үлдэгдэл 15,2 сая төгрөгөөр, ЦШСГ-ын бараа материал 8,9 сая төгрөгөөр, "Хала өркени" ОНӨӨҮГазрын бараа материалын үлдэгдэл 2,8 сая төгрөгөөр тус тус буурч, "Сансар" эмнэлгийн бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 10,3 сая төгрөгөөр, Эргэлтийн эмийн сангийн бараа материалын үлдэгдэл 15,2 сая төгрөгөөр өссөн байна.

## 5.4 ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланда хийсэн аудитаар бараа материалтай холбоотой гарсан зөрчлийн талаар

Аудитаар Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагын НББ, санхүүгийн тайланг гаргах заавар аргачлал"-ыг зөрчиж акталсан бараа материалыг үр дүнгийн тайланд үйл ажиллагааны зардалд оруулан тайлагнасан 8,6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Алтай сумын хүүхдийн цэцэрлэг 737,5 мян төгрөгийн, Алтанцөгц сумын хүүхдийн цэцэрлэг 2314,5 мян төгрөгийн, Булган сумын хүүхдийн цэцэрлэг 4554,3 мянган төгрөгийн акталсан аж ахуйн материалыг үйл ажиллагааны зардалд оруулан тайлагнасан, Ногооннуур сумын хүүхдийн цэцэрлэг 1054,1 мянган төгрөгийн худалдан авсан компьютерийг бараа материалын дансанд орлого авсныг залруулсан.

## Зургаа. Үндсэн хөрөнгийн талаар

### 6.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагнналын талаар

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө 2016 оны эцэст 154,422.8 сая төгрөг байсан бол тайлант онд 5,1 хувь буюу 8017,3 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 162,440.1 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

#### Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

(сая.төг)

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү дүн
Барилга байгууламж	102,753.80	106,972.20	4218.4
Тээврийн хэрэгсэл	4,472.70	4,536.90	64.2
Машин тоног төхөөрөмж	24,441.50	26,437.10	1995.6
Тавилга эд хогшил	5,742.80	5,554.40	-188.4
Дуусаагүй барилга	3,665.50	3,736.90	71.4
Зам, гүүрийн байгууламж	2,179.70	2,822.10	642.4
Биет бус хөрөнгө	109.4	124.3	14.9
Бусад үндсэн хөрөнгө	11,057.40	12256.2	1198.8
<b>Дүн</b>	<b>154,422.80</b>	<b>162,440.10</b>	8017.3

Нийт үндсэн хөрөнгийн 65.8 хувийг барилга байгууламж, 2.8 хувийг тээврийн хэрэгсэл, 16.3 хувийг машин тоног төхөөрөмж, 3.4 хувийг тавилга, эд хогшил, 2,3 хувийг дуусаагүй барилга байгууламж, 1.7 хувийг зам гүүрийн барилга байгууламж, 0.1 хувийг биет бус хөрөнгө, 7.5 хувийг бусад үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 10,486.5 сая төгрөгөөр /үүний дотор худалдан авсан 322,4 сая, хандив тусламжаар 4,849.0 сая, шилжүүлж авсан 1,336.3 сая, бүтцийн өөрчлөлтөөр 27.5 сая, бусад эх үүсвэрээр 3,951.2 сая төгрөгөөр/ нэмэгдэж, 2,689.9 сая төгрөгөөр хасагдаж /үүний дотор акталсан 358,5 сая, шилжүүлсэн 1,290.3 сая, бүтцийн өөрчлөлтөөр 1,036.9 сая, бусад 4,2 сая/ оны эцэст 162,219.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. Тайлант онд үндсэн хөрөнгөнд нийтдээ 5,822.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Тайлант онд барилга байгууламж 3670,0 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 64,3 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 1962,8 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 145,1 сая төгрөгөөр, зам гүүрийн барилга байгууламж 118,4 сая, биет бус хөрөнгө 4,4 сая төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө 1954,6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХСангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг орлогод авсантай холбоотой байна. Дуусаагүй барилга байгууламжийн үлдэгдэл 118,4 сая төгрөгөөр буурчээ.

#### 6.2 ОНӨҮГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨ ДАНСНЫ ТАЛААР

ОНӨҮГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЛДЭГДЛИЙГ ХАРУУЛБАЛ ДАРААХ БАЙДАЛТАЙ БАЙНА:

/сая.төгрөгөөр/

№	ОНӨААН байгууллагууд	Үндсэн хөрөнгө		Өсөлт, бууралт
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	"Жана өлкө" ОНӨҮГ	3,343.30	3,094.70	(248.60)
2	"Суат" ХХК	3,757.70	3,848.90	91.2
3	ЦШСГ	7,897.20	8,668.70	771.50
4	"Хала өркени" ОНӨҮГ	2,541.50	2,311.30	(230.20)
5	"Сансар" эмнэлгэ	164.60	153.10	(11.50)
<b>Бүгд дүн</b>		<b>17,704.3</b>	<b>18,076.70</b>	<b>372.4</b>

Өмнөх онтой харьцуулж үзвэл “Хала өркени” ОНӨОҮГазрын үндсэн хөрөнгө 230,2 сая төгрөгөөр, “Сансар” эмнэлгийн үндсэн хөрөнгө 11,5 сая төгрөгөөр, “Жана өлкө” ОНӨТҮГазрын үндсэн хөрөнгө 248,6 сая төгрөгөөр тус тус буурч, ЦШСГ-ын үндсэн хөрөнгө 771,5 сая төгрөгөөр, “Суат” ХХК-ны үндсэн хөрөнгө 73,0 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

### **6.3 ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланда хийсэн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлүүдийн талаар**

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланда хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 12,1 сая төгрөгийн дараах алдаа зөрчил илэрч залруулга хийсэн. Үүнд:

- Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэг бусад үндсэн хөрөнгө, машин тоног төхөөрөмжийн элэгдлийг 4833,0 мян төгрөгөөр илүү тооцсон.
- Ногооннуур сумын хүүхдийн цэцэрлэг 1054,1 мянган төгрөгийн худалдан авсан компьютерийг бараа материалын дансанд орлого авч бүтгэсэн.
- Сагсай сумын хүүхдийн цэцэрлэг 6258.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгөнд элэгдэл байгуулаагүй тайлагнасан байна.

#### **Долоо.Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал**

### **7.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар**

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланда нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5,394.8 сая төгрөг байснаас тайланда онд 211,9 сая төгрөгөөр өсч, оны эцэст 5,606,7 сая төгрөгт хүрсэн байна.

*Нийт өр, төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний		Зөрүү
	үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>2,247.20</b>	<b>2,121.00</b>	-126.20
Богино хугацаат зээлийн өглөг	140.5		-140.50
Өглөг	1,823.60	2,054.90	231.30
Урьдчилж орсон орлого	283.1	66.1	-217.00
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>3,147.60</b>	<b>3,485.70</b>	338.10
Урт хугацаат зээл	3,147.60	3,485.70	338.10
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>5,394.80</b>	<b>5,606.70</b>	211.90

Тайлант хугацааны эцэст нийт өр төлбөрийн 37,8 хувийг богино хугацаат өр төлбөр, 62,2 хувийг урт хугацаат өр төлбөр тус тус эзэлж байна. Богино хугацаат өр нийт дүнгээр 126.2 сая төгрөгөөр буурсны дотор Засгийн газарт төлөх зээл 135,3 сая төгрөгөөр буурчээ. Засгийн газарт төлөх зээлийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс суутгасантай холбоотой буурсан байна.

*Өр төлбөрийг салбараа нь задалж харуулбал:*

өглөгийн нийт дүн	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	зөрүү	хувиар
Төрийн сан	135.30		(135.30)	-

Төрийн өмчийн үйлдвэрийн газар	4,433.20	4,411.20	(22.00)	99.50
Төсөвт байгууллага	826.40	1,195.50	369.10	144.66
Төсөл сангүүд	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>5,394.90</b>	<b>5,606.70</b>	<b>211.80</b>	<b>103.93</b>

Нийт өглөгийн 4411,2 сая төгрөг буюу 78,7 хувийг ОН-ийн өмчит үйлдвэрийн газрын, 1195,5 сая төгрөг буюу 21,3 хувийг төсөвт байгууллагын өглөг эзлэж байна.

## 7.2 Өр, төлбөртэй холбоотой гарсан зөрчил, дутагдлын талаар

ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланда хийсэн аудитаар өр, төлбөртэй холбоотой дараах зөрчил, дутагдал илэрлээ.Үүнд:

- Өлгий сумын 1-р бүрэн дунд сургууль, Баяннуур ЗДТГазар, Булган сумын Ёлт бага сургууль зэрэг байгууллагууд шинээр өглөг үүсгэсэн.
- Ногооннуур сумын бүрэн дунд сургууль нь он дамжсан 4,4 сая төгрөгийн өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй.
- Орон нутгийн өмчийн газар, Хот тохижуулах алба, Өлгий сумын 4-р бүрэн дунд сургууль, Бугат, Буянт, Сагсай сумын бүрэн дунд сургууль, Даянгийн бага сургууль, Өлгий сумын 5-р хүүхдийн цэцэрлэг, 9-р хүүхдийн цэцэрлэг, Баяннуур, Булган сумын Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд ХХОАТатвар, НДШ-ийг дутуу шилжүүлсэн, үүссэн нийт 15,6 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланда тусгаж харуулаагүй байнсыг нөхөн төлүүлэхээр акт тогтоосон.
- Сумдын ТТЗ-дын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний дутуу олгогдсон нтй 287,7 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн өглөгийг санхүүгийн тайланда өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулсан.

Дээрх байдал нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж, өр, төлбөр үүсгэхгүй байх”, 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэсэн заалтуудыг тус тус хангахгүй байна.

## 7.3 Урт хугацаат өр, төлбөрийн талаар

Тайлант оны эхэн ба эцэст урт хугацаат өр төлбөр 3485,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд түүний 991.0 сая төгрөг нь НААҮ-ийн “Суат” ХХК-ны Азиин хөгжлийн банкинд төлөх урт хугацаат зээл, 2136,6 сая төгрөг нь Цахилгаан шугам сүлжээний газрын Дэлхийн банкинд төлөх урт хугацаат зээлийн төлбөр байна. 220,0 сая төгрөг нь Засгийн газрын болон бусад шатны төсвийн, 138,0 сая төгрөгийн зээл нь хувь хүмүүсийн зээл байна. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад өгсөн зээлийг аймгийн төвд цэвэр усны магистраль шугам татах, цахилгааны кабель шугам татахад зориулан олгожээ.

## Найм. Орлогын бүртгэл, тайлагнал

### 8.1 ТЕЗ-ийн нэгдсэн тайлангаарх орлогын бүтцийн талаар

2016 оны ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаарх үйл ажиллагааны орлогын нийт дүн 89900,8 сая төгрөг бөгөөд өмнөх онтой харьцуулахад 11909,1 сая төгрөгөөр буурсан байна.

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү /сая төгрөг/
Татварын орлого	6,072.50	6,489.10	416.60
Татварын бус орлого	10,870.60	6,286.20	-4,584.40
Тусlamж санхүүжилтийн орлого	84,866.80	77,125.50	-7,741.30
Улсын төвлөрсөн төсвөөс	55,095.10	47,596.50	-7,498.60
Нэмэлт санхүүжилтийн орлого	677	1,778.10	1,101.10
Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,111.10	19,219.20	4,108.10
Төсвийн захирагчаас	13,149.40	7,817.40	-5,332.00
НД-ын сангаас	833.5	714.3	-119.20
<b>Үйл ажиллагааны орлогын нийт дүн</b>	<b>101,809.90</b>	<b>89,900.80</b>	<b>-11,909.10</b>

Нийт орлогын 6489,1 сая төгрөгийг татварын орлогоос, 6286,2 сая төгрөгийг татварын бус орлогоос, 77125,5 сая төгрөгийг тусlamж санхүүжилтийн орлого бүрдүүлж байна.

Тусlamж санхүүжилтийн орлогоос 77125,6 сая төгрөгийн орлого орсоноос 47596,5 сая төгрөгийг Улсын төвлөрсөн төсвөөс, 1778,1 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн орлогоос, 19219,2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 7817,4 сая төгрөгийг төсвийн захирагчаас, 714,3 сая төгрөгийг НД-ын сангаас тус тус авсан байна.

## 8.2 Татварын болон татварын бус орлогын талаар

2016 оны ОН-ийн төсвийн орлого 18,408.8 сая төгрөгөөр төлөвлөгдж, гүйцэтгэлээр 18,413.1 сая төгрөгийн биелэлттэй, ОН-ийн төсвийн орлогыг 0.02 хувиар буюу 4,3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн дүнтэй байна.

Татварын орлогоос нийтдээ 6782,2 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 6921,8 сая төгрөг оруулж, орлогын төлөвлөгөөг 102,1 хувиар буюу 139,6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Үүнээс: хувь хүний орлогын албан татвараас 5083,7 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 100,2 хувиар буюу 9,3 сая төгрөгөөр, өмчийн татварын орлогоос 273,8 сая төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 126,3 хувиар буюу 57,0 сая төгрөгөөр, дотоодын бараа үйлчилгээний татварын орлогоос 292,4 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 116,0 хувиар буюу 40,4 сая төгрөгөөр, байгалийн нөөц ашигласны төлбөрөөс 468,8 сая төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 120,7 хувиар буюу 80,4 сая төгрөгөөр давж биелэгдэж, бусад татварын орлогоос 411,7 сая төгрөг оруулж, орлого 5,8 хувиар буюу 25,4 сая төгрөгөөр, татварын бус орлогоос 391,3 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 5,4 хувиар буюу 22,2 сая төгрөгөөр тасарчээ.

Татварын бус орлогын 14,5 хувь буюу 56,6 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлого, 85,5 хувийг буюу 334,7 сая төгрөгийг хүү, торгууль, бусад орлого эзэлж байна.

Орон нутгийн татварын орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

/мян/төгрөгөөр/ Îðëîâûí ð°ð°ë	Төлөвлөгөө Гүйцэтгэл	Зөрүү
----------------------------------	-------------------------	-------

			дүнгээр	хувиар
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>18,408.8</b>	<b>18,413.0</b>	4.2	100.0
<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	<b>6,782.2</b>	<b>6,921.7</b>	139.5	102.1
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>6,368.7</b>	<b>6,530.4</b>	161.7	102.5
<b>Орлогын албан татвар</b>	<b>5,074.4</b>	<b>5,083.7</b>	9.3	100.2
<b>ХАОАТатвар</b>	<b>5,074.4</b>	<b>5,083.7</b>	9.3	100.2
Öàëëí õ°ëñ ò¿¿íòýé àäëëðääð ïðëëïðûí àëääí òäðääð	5,462.3	5,530.1	67.8	101.2
Үйл ажиллагааны орлого		539.9	539.9	#DIV/0!
Îрлогыг тодорхойлох боломжгүй ИОТàðääð	507.7	3.6	(504.1)	0.7
Хувиара аж ахуй эрхэлсний орлогын таðääð	65.0		(65.0)	-
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар		45.7	45.7	#DIV/0!
ШУУЗУБТБА3Бүтээх орлогын татвар			-	#DIV/0!
Шууд бус орлого	2.5	47.0	44.5	1,880.0
Хувиараа бараа материал бэлтгэсний татвар			-	#DIV/0!
ХХОАТатварын буцаан олголт	(963.1)	(1,082.6)	(119.5)	112.4
<b>Өмчийн татвар</b>	<b>216.8</b>	<b>273.8</b>	57.0	126.3
— ё õ°äë°õ õ°õíäééí албан òäðääð	150.1	214.7	64.6	143.0
Áóóíû àëääí òäðääð	66.7	59.1	(7.6)	88.6
<b>Дотоодын бараа, үйлчилгээний татвар</b>	<b>252.0</b>	<b>292.4</b>	40.4	116.0
ÀØäØÀÒàðääð	252.0	292.4	40.4	116.0
<b>Бусад татвар</b>	<b>437.1</b>	<b>411.7</b>	(25.4)	94.2
Óëñûí òýïäýäðèéí õóðääìæ	305.0	266.0	(39.0)	87.2
Ãàçðûí õ°éá°ð	97.5	115.1	17.6	118.1
Ò¿äýüïë òäðääððäé àøèäð ìàëðïäé àøèäéàñíû õ°éá°ð	30.0	18.8	(11.2)	62.7
Хог хягдалын үйлчилгээний хураамж	4.6	0.016	(4.6)	0.3
АМБББАОЭЗХураамж		0.5	0.5	
бусад татвар		11.3	11.3	
<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>388.4</b>	<b>468.8</b>	80.4	120.7
Үс, рашаан ашигласны төлбөр	48.0	17.9	(30.1)	37.3
Îéäïñхэрэглээний ïä, ò¿¿éýú áýéðäýæ àøèäéàñíû õ°éá°ð	42.6	25.4	(17.2)	59.6
Байгалийн ургамлын НАТөлбөр	297.8	0.5	(297.3)	0.2
Аннуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж		425.0	425.0	
<b>II.Татварын бус орлого</b>	<b>413.5</b>	<b>391.3</b>	(22.2)	94.6
Хувьцааны ноогдол ашиг			-	
Хүүгийн орлого		29.3	29.3	
Торгуулийн орлого	250.0	299.7	49.7	119.9
Түрээсийн орлого			-	
Төсөвт газрын өөрийн орлого	51.3	56.6	5.3	110.3

Бусад нэр заагдаагүй орлого	112.2	5.7	(106.5)	5.1
<b>Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	-	-	-	-
Хөрөнгө худалдсаны орлого			-	-
Өмч хувьчлалын орлого			-	-
<b>В.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>11,626.6</b>	<b>11,491.3</b>	(135.3)	98.8
1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	11,626.6	11,491.3	(135.3)	98.8

Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 1,2 хувиар буюу 135,3 сая төгрөгөөр дутуу олгогдсон нь Засгийн газарт төлөх зээлийг улсын төсвөөс авах дэмжлэгээс хасч олгосонтой холбоотой.

ХХОАТатвар нийт дүнгээр 530,6 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна. Үүнээс : цалин, түүнтэй адилтгах орлогын албан татвар 67,8 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлого буюу орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй иргэдийн орлогын албан татвар 35,7 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгө борлуулсны албан татвар 45,7 сая төгрөгөөр, шууд бус орлогын албан татвар 44,5 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.

Өмчийн татвар 64,6 сая төгрөгөөр давж биелэгдсэний дотор үүнээс үл хөдлөх хөрөнгийн албан татвар 143,0 хувиар давж, бууны албан татвар 11,4 хувиар тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 10,5 хувиар буюу 5,4 сая төгрөгөөр давж биелэгдсэн боловч өөрийн орлогын төлөвлөгөөг БОАЖГазар 1,7 сая төгрөгөөр буюу 49,3 хувиар тасалсан байна.

*Сумуудын ОН-ийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сум тус бүрээр харуулбал:*

/мян/төгрөгөөр/

№	Сумын нэр	2016 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Алтай	26,303.0	73,470.8	47,167.8	279.3
2	Алтанцөгц	18,236.5	17,757.6	-478.9	97.4
3	Баяннуур	18,038.1	24,210.6	6,172.5	134.2
4	Бугат	48,667.1	64,133.9	15,466.8	131.8
5	Булган	45,628.0	117,869.4	72,241.4	258.3
6	Буянт	48,608.0	97,180.9	48,572.9	199.9
7	Дэлүүн	167,312.0	146,363.5	-20,948.5	87.5
8	Ногооннуур	30,272.0	30,847.1	575.1	101.9
9	Сагсай	24,315.0	32,917.5	8,602.5	135.4
10	Толбо	24,272.1	29,945.3	5,673.2	123.4
11	Улаанхус	96,128.0	112,626.7	16,498.7	117.2
12	Цэнгэл	67,285.0	59,296.0	-7,989.0	88.1
13	Цагааннуур	4,964.6	6,392.7	1,428.1	128.8
14	Өлгий	352,961.1	351,255.1	-1,706.0	99.5
15	Татварын хэлтэс	5,809,253.5	5,700,935.0	-108,318.5	98.1
	<b>БҮГД</b>	<b>6,782,244.0</b>	<b>6,865,202.1</b>	<b>82,958.1</b>	<b>101.2</b>

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг Дэлүүн, Цэнгэл, Өлгий сумаас бусад сумууд 1,9-279,3 хувиар давуулан биелүүлжээ. Дэлүүн сум ангийн орлогоос урьдчилж орсон 38,3 сая төгрөгийг тайлант оны орлогод оруулсаныг залруулж, гүйцэтгэлээс хассанаар орлогын төлөвлөгөө 20,9 сая төгрөгөөр тасарсан байна.

Дэлүүн сум 20,9 сая төгрөгөөр буюу 12,5 хувиар, Цэнгэл сум 7,9 сая төгрөгөөр буюу 11,9 хувиар, Өлгий сум 1,7 сая төгрөгөөр буюу 0,5 хувиар орлогын төлөвлөгөөг тасалдуулж Төсвийн тухай хуулийн 41.2.1-т "хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

### **Ес. Зардлын бүртгэл, тайлагнал**

#### **9.1 ТЕЗ-ийн нэгдсэн тайлангаарх зардлын бүтцийн талаар**

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайланд нийт зардал 87665,1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч өмнөх оноос 4506,1 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна. Нийт зардлыг эдийн засгийн ангиллаар өмнөх болон тайлант оны зардлын эзлэх хувийг хүснэгт №1-д харуулав.

*Нийт зардлыг бүтцээр нь харуулбал: Хүснэгт №1*

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	/сая төгрөгөөр/ ЭЗЛЭХ ХУВЬ
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>83,159.00</b>	<b>87,665.10</b>	<b>105.4</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>83,159.00</b>	<b>83,771.90</b>	<b>100.7</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>60,704.60</b>	<b>63,997.20</b>	<b>105.4</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	35,554.40	36,330.60	102.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,884.30	4,071.60	104.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,950.00	6,767.70	113.7
Хангамж, бараа материалын зардал	1,233.40	1,242.70	100.8
Нормативт зардал	8,879.00	3,651.90	41.1
Эд хогшил, урсгал засварын зардал	230.5	278.3	120.7
Томилолт, зочны зардал	274.6	190.5	69.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	550.1	1596.2	290.2
Бараа үйлчилгээний бусад зардал	4,148.30	9,867.70	237.9
<b>ТААС</b>			<b>10.2</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,461.20</b>	<b>3,893.20</b>	<b>87.3</b>
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,993.20</b>	<b>19,764.50</b>	<b>109.8</b>

Нийт зарлагын 73,0 хувийг буюу 63997,2 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардал, 4,4 хувийг буюу 3893,2 сая төгрөгийг хөрөнгийн зардал, 22,5 хувийг буюу 19764,5 сая төгрөгийг урсгал шилжүүлэг, 0,001 хувийг буюу 10,2 сая төгрөгийг татаас санхүүжилтийн зардал тус тус эзлэж байна.

,

,

## 9.2 Бараа үйлчилгээний зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

Аудитаар бараа үйлчилгээний зардалтай холбоотой нийтдээ 75,5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

- Буянт сумын Бүрэн дунд сургууль 5,5 сая төгрөгийг, Улаанхус сумын хүүхдийн цэцэрлэг 8,3 сая төгрөгийг, Хөххөтөл хүүхдийн цэцэрлэг 1,7 сая төгрөгийг, Согог дунд сургууль 9,4 сая төгрөгийг хоолны зардлын хэмнэлтээс зохих зөвшөөрөлгүйгээр бусад зардалд гүйлгэн зарцуулсан зөрчлийг дахин давтахгүй байх, төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулахыг зөвлөмж болгов.
- Цэнгэл сумын Тыва бага сургууль 1,1 сая төгрөгийн, Загастнуурын бага сургууль 1,0 сая төгрөгийн, Алтай сумын Улаанхад бага сургууль 0,5 сая төгрөгийн Үдийн цайны санхүүжилтийг үдийн цайг гэрээгээр гүйцэтгэгч байгууллагад гүйцэтгэлээс илүү олгож зориулалт бус зарцуулсаныг нөхөн төлүүлэхээр акт тогтоосон.
- Дэлүүн сумын Бүрэн дунд сургууль хоолны зардлын хэмнэлтээс нийтдээ 25,2 сая төгрөгийг сумын ИТХурал, Засаг даргын зөвшөөрөлөөр тавилга эд хогшил худалдан авахад зарцуулж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, Сангийн сайдын 2009 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 560/276 тоот хамтарсан тушаал, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын холбогдох заалтууд, Монгол Улсын Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.2.в-д заасан “...тавилга эд хогшил худалдаж авах зардал... зэргийг төсвөөс санхүүжүүлэхгүй байх”, Засгийн газрын 2016 оны 38 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-д “Монгол улсын 2016 оны төсвийн жил дуусах хүртэлх хугацаанд төсвийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлж, бүх шатны төсөвт байгууллагын зарцуулаагүй үлдэгдлийг бууруулах”, уг тогтоолын 1.2-т “ 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс хойш бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг зарлахгүй байх, гэрээ байгуулахгүй байх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.4, 39 дүгээр 39.4.2, 41 дүгээр 41.2.2, 42 дугаар зүйлийн 42.2.3, 42.3, 45 дугаар зүйлийн 45.2, 45.2.1 дахь заалтуудыг зөрчсөн.
- Өлгий сумын 4 дүгээр бүрэн дунд сургууль түлш халаалтын зардлаас халаалтын үнэ тариф, сургуулийн талбайн хэмжээнд өөрчлөлт ороогүй байхад “Эрчим”ХК-нд гэрээний дүнгээс 8,6 сая төгрөгийг илүү шилжүүлсэнийг нөхөн төлүүлэхээр акт тогтоосон.
- Биеийн тамир спортын газар 9,4 сая төгрөгийн, Музей 4,8 сая төгрөгийн туслах үйл ажиллагаанаас орсон орлогыг жижиг мөнгөн санд хүлээн авч, зохих зөвшөөрөлгүйгээр зарцуулж батлагдсан төсөвт тусгагдаагүй зарлага гаргаж Төсвийн тухай хуулийн 41.2.2, 47.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-ын 2.6 дахь заалтыг зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн харьяа байгууллагуудаас илэрсэн нийт алдаа зөрчлийн 2058,3 сая төгрөгийг буюу 98,7 хувийг төсвийн байгууллагуудын санхүүгийн бүртгэл тайлагналтай холбоотой алдаа зөрчил эзэлж байгаа бөгөөд үүнээс 383,0 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлагналтай холбоотой, 1675,2 сая төгрөг нь сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн нэгтгэлтэй холбоотой алдаа зөрчил байна.

- Өлгий сумын ЗДТГазар санхүүгийн тайланг хугацаа хожимдуулан ирүүлсэний дээр аудитын дүгнэлт гаргахад шаардлагатай санхүүгийн баримт материалуудыг гаргаж ирүүлээгүй.

- Орон нутгийн өмчийн газар орлого, зардлыг болон төсвийн гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан, элэгдлийг дутуу байгуулсан зэргээр санхүүгин тайланг 18,3 сая төгрөгийн алдаатай гаргаж, ОНӨГазрын Хөгжлийн сангийн тайланда тусгагдсан 54,3 сая төгрөгийн он дамжсан авлагыг харилцагч байгууллага бүрээр тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажулаагүй байна.
- Сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар Орон нутгийн хөгжлийн сангаас дутуу олгосон 196,9 сая төгрөгийн санхүүжилтийг авлагаар тусгаж харуулаагүй, ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний дутуу олгогдсон 287,7 сая төгрөгийн санхүүжилтийн өглөгийг санхүүгийн тайланда өглөгөөр тусгаагүй нийтлэг зөрчил илэрсэн.
- Үүнээс Дэлүүн сумын ТТЗ-ийн СНТайлангаас 104,5 сая төгрөгийн, Улаанхус сумын ТТЗ-ийн СНТайлангаас 323,9 сая төгрөгийн, Цагааннуур тосгоны ТТЗ-ийн СНТайлангаас 452,6 сая төгрөгийн, Цэнгэл сумын ТТЗ-ийн СНТайлангаас 78,2 сая төгрөгийн, Өлгий сумын ТТЗ-ийн СНТайлангаас 413,3 сая төгрөгийн орлого, зардал, төсвийн гүйцэтгэлийг зөрүүтэй нэгтгэсэн, мөнгөний үлдэгдэл, авлага, өглөгийг дутуу тусгасан зэрэг бүртгэл тайлагналтай холбоотой алдаа зөрчил илэрч сумуудын тайлангаас илэрсэн алдаа зөрчлийн 84,7 хувийг эзэлж байна.
- Аудитын дүнгээр Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ыг зөрчсөн 7 төсөвт байгууллага, 2 сумын ТТЗ-ийн СНТайлантай холбоотой нийтдээ 40,8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөгдсөн байна.
- Мөн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ХХОАТ-ын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтуудыг болон Засгийн газрын 2012 оны 78 дугаар тогтоол, 2014 оны 332 дугаар тогтоол, 2012 оны 106 дугаар тогтоол, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, Сангийн сайдын 560/276 тоот хамтарсан тушаал, Монгол Улсын Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.2.в, Засгийн газрын 2016 оны 38 дугаар тогтоолын заалтыг зөрчсөн нийт 63,8 сая төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон байна.

#### 9.4 Эзэмшигчийн өмч, хуримтлагдсан үр дүнгийн талаар

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар эзэмшигчийн өмч 109082,1 сая төгрөг болсон байна. Үүнээс ЗГОКапитал 58564,0 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 25778,5 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 24739,6 сая төгрөг байна. ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар тайлант онд 1463,8 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж, хуримтлагдсан үр дүн 24739,6 сая төгрөг болж өссөн дүнтэй байна

#### Арав. ОН-ийн өмчит үйлдвэрийн газрын бүртгэл, тайлагнал

##### 10.1 ОН-ийн өмчит байгууллагуудын бүтцийн талаар

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланда ОНӨААНэгж болох Цахилгаан шугам сүлжээний газар, “Суат” ХХК, “Хала өркени” ОНӨАОҮГазар, “Жана өлке” ОНӨААТҮГазар, “Өлгий сансар” эмнэлэг, Алтай, Алтанцэгц, Бугат, Булган, Буянт, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Толбо, Улаанхус, Цагааннуур, Цэнгэл сумдын эргэлтийн эмийн сан зэрэг 17 ОНӨААН-ийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

ОН-ийн өмчит байгууллагуудын 2016 оны орлого, зарлага, хуримтлагдсан үр дүн

ДД	Аймаг, Нийслэлийн нэр	ОНӨҮГ-ЫН тоо	Орлого	Зарлага	2016 оны үр дүн	Өмнөх үеийн үр дүн	/сая төгрөг/ Хуримтлагдсан үр дүн
							Хуримтлагдсан үр дүн
1	Баян-Өлгий	17	6457,9	6134,6	323,3	-2569,9	-2246,6
	<b>Нийт</b>	<b>17</b>	<b>6457,9</b>	<b>6134,6</b>	<b>323,3</b>	<b>-2569,99</b>	<b>-2246,6</b>

## 10.2 ОН-ЫН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН ТАЛААР

ОН-ЫН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР “Суат” ХХК, “Хала өркени” ОНӨАОҮГазар, “Жана-Өлкө” ОНӨААТҮГазар, “Өлгий сансар” эмнэлэг зэрэг байгууллагууд “зөрчилгүй санал дүгнэлт” авсан ба ЦШСГ-т тайлант онд итгэл үзүүлсэн.

- “Суат” ХХК нь санхүүгийн тайланд 2015 оноос Нэгдсэн эмнэлгтэй холбоотой 27,6 сая төгрөгийн авлагыг бүртгэж ирсэн боловч харилцагч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, тухайн авлагыг харилцагч байгууллага нь хүлээн зөвшөөрөөгүй, авлагын насхилт нэмэгдсэн байна.

Бусад ОНӨААН Байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илэрээгүй байна.

## 10.3 ТЕЗ-ИЙН ТАЙЛАНД НЭГТГЭГДСЭН ТӨСӨЛ, САНГИЙН ТАЛААР

ТЕЗ-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ДАРААХ САНГУУД НЭГТГЭГДСЭН БАЙНА. ҮҮнд: 14 СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН, 3 СУМЫН БХСАН, БУЯНТ СУМЫН ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САН, МАЛ ХАМГААЛАХ САН, ЭХЭМДСАН БОЛОН ДЭЛЛҮҮН СУМЫН ЭХЭМДС, ОРОН НУТГИЙН ХО-ЫН САН, АЙМГИЙН БОХСАН, БУСАД САН, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭЛТИЙН САН, ОРОН НУТГИЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР ЗЭРЭГ 26 ТӨСӨЛ САНГИЙН ТАЙЛАН НЭГТГЭГДСЭН БАЙНА.

## 10.4 ТӨСӨЛ, САНГУУДЫН МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЛААР

САНГУУДЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН МӨНГӨН ХӨРӨНГИЙН ҮЛДЭГДЭЛИЙГ ХҮСНЭГТЭЭР ХАРУУЛБАЛ :

ДД	Сангийн нэр	Сантай / тоо/	/сая төгрөг/ Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл
			ДҮН
1	Байгаль хамгалах сан	4	12,6
2	Мал хамгаалах сан	2	1,3
3	Бусад сан	1	7,1
4	Хүүхдийн төлөө сан	1	0
5	Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих сан	2	2,1
6	Сум хөгжүүлэх сан	14	44,7
7	Орон нутгийн ХО-ЫН сан	1	429,9
8	Нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлт	1	8,2
	<b>ДҮН</b>	<b>26</b>	<b>505,9</b>

## 10.5 Төсөл, сангудын авлага, өр төлбөрийн талаар

ОН-ийн тусгай сангудын 2016 оны авлагын нийт үлдэгдэл 4138,6 сая төгрөг байгаагаас 4065,3 сая төгрөг буюу 98,2 хувь нь СХСангаас олгосон зээлийн авлага, 73,3 сая төгрөг буюу 1,7 хувь нь ХО-ын сангийн авлага байна.Өмнөх онтой харьцуулахад ОН-ын тусгай сангудын авлага 14,4 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Санхүүгийн тайланд орон нутгийн ХО-ын сангийн 180,7 сая төгрөгийн өглөг тусгагдсан байна.

### Арван нэг. ОН-ийн тусгай шилжүүлгийн талаар

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан.Үүнд:

- Ерөнхий боловсрол
- Сургуулийн өмнөх боловсрол
- Соёлын үйлчилгээ
- Эрүүл мэндийн анхан шатны тусlamж үйлчилгээ
- Газрын харилцаа, кадастр
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ
- Нийтийн биеийн тамир

## 11.1 ТЗШ-ийн байгууллагуудын мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 2016 оны эцэст нийтдээ 1,3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 1,1 сая төгрөгөөр өссөн байна. /мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бага тоогоор гарч байгаа тул үлдэгдлийг мянган төгрөгөөр гаргав/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Арилжааны банк	/мянган төгрөгөөр/ Банкинд байгаа бэлэн мөнгө	Төрийн сангийн нэгдсэн данс
Кассад байгаа бэлэн мөнгө	53.1	778.8	778.8			
Төгрөг/ЖМС	53.1	778.8	778.8			
Банкинд байгаа бэлэн мөнгө	124.7	517.8	0		517.8	
Төгрөг	124.7	517.8	0		517.8	
<b>Нийт мөнгөн хөрөнгийн дүн</b>	<b>177.8</b>	<b>1,296.6</b>	<b>778.8</b>		<b>517.8</b>	

Мөнгөн хөрөнгийн 0,8 сая төгрөгийг касст байгаа бэлэн мөнгө, 0,5 сая төгрөгийг арилжааны банкинд байгаа мөнгөний үлдэгдэл эзлэж байна.

## 11. 2. Авлагын бүртгэл, тайлагнал

Тусгай шилжүүлгийн байгууллагуудын авлагын бүтэц дараах байдалтай байна.

/сая төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	12,0	16.7	3.6	16.4
Төлбөртэй үйлчилгээний авлага		0.3	0.3	0.3

Татвар, НДШ – ийн авлага		1.8	1.8	1.8
<b>Бусад авлага</b>	<b>38.1</b>	<b>83.1</b>	<b>42.6</b>	<b>81.6</b>
Байгууллагаас авах авлага	4.1	59.4	53.1	58.3
Хувь хүмүүсээс авах авлага	34	23.7	-10.5	23.3
<b>Нийт авлагын дүн</b>	<b>50.1</b>	<b>101.9</b>	<b>48.3</b>	<b>100.0</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:</b>				
ЕБСургуулиуд	42.4	86.7	44.24	85.1
СТөвүүд	0.4	0.2	-0.17	0.2
Хүүхдийн цэцэрлэгүүд	5.2	8.4	1.3	8.2
ЭМСалбар	2.2	0.6	-1.52	0.6
ГХБХБГазар	1.4	6	4.49	5.9
<b>ДҮН</b>	<b>51.6</b>	<b>101.9</b>	<b>48.3</b>	<b>100.0</b>

Авлагын үлдэгдэл өмнөх оноос 48,3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Авлагыг бүтцээр авч үзвэл: Оны эцсийн нийт авлагын 16,7 сая төгрөгийг ажиллагчидтай холбогдсон авлага, 0,3 сая төгрөгийг төлбөртэй үйлчилгээний авлага, 1,8 сая төгрөгийг татвар, НДШ-ийн авлага, 59,4 сая төгрөгийг байгууллагаас авах авлага, 23,7 сая төгрөгийг хувь хүмүүсээс авах авлага байна.

Нийт авлагын 86,7 сая төгрөгийг ЕБСургуулийн авлага, 0,2 сая төгрөгийг Соёлын төвийн авлага, 8,4 сая төгрөгийг Хүүхдийн цэцэрлэгийн авлага, 0,6 сая төгрөгийг ЭМСалбарын авлага, 6,0 сая төгрөгийг ГХБХБГазрын авлага эзлэж байна.

### 11.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал

Тусгай зориулалтын шилжүүлгийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланда бараа материалын эцсийн үлдэгдэл 2798,2 сая төгрөгөөр тайлагнагдаж, оны эхнээс 330,2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	/сая төгрөгөөр/ хувь
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>2,457.0</b>	<b>2,787.2</b>	<b>330.2</b>	<b>11.8</b>
Түүхий эд материал	88.7	99.4	10.7	10.8
Тусгай зориулалттай материал	28.8	45.2	16.4	36.2
Эм боох материал	59.9	54.2	(5.7)	(10.4)
Дуусаагүй үйлдвэрлэл	10.0	19.2	9.2	48.0
Бэлэн бүтээгдэхүүн	30.2	48.7	18.5	38.0
<b>Хангамжийн материал</b>	<b>2,245.5</b>	<b>2,542.0</b>	<b>296.5</b>	<b>11.7</b>
Бичиг хэргийн материал	49.8	54.2	4.4	8.1
Аж ахуйн материал	941.5	1,035.3	93.8	9.1
Сэлбэг хэрэгсэл	4.6	4.0	(0.6)	(14.9)
Түлш, шатах тослох материал	141.7	171.8	30.1	17.5
Барилгын засварын материал	13.7	10.1	(3.6)	(35.5)
Хүнсний материал	310.8	453.8	143.0	31.5
Бусад хангамжийн материал	790.8	820.9	30.1	3.7
Мал амьтад	75.0	68.8	(6.2)	(9.0)

Нийт бараа материалын үлдэгдэлд түхий эд материал 3,6 хувь буюу 99,4 сая төгрөгийг, хангамжийн материал 96,4 хувь буюу 2542,0 сая төгрөгийг эзэлж байна.

Бараа материалын жилийн эцсийн үлдэгдлийн 59,7 хувийг буюу 1664,6 сая төгрөгийг ЕБСургуулийн, 3,5 хувийг буюу 96,5 сая төгрөгийг Соёлын төвийн, 26,4 хувийг буюу 736,3 сая төгрөгийг Хүүхдийн цэцэрлэгийн, 9,3 хувийг буюу 260,5 сая төгрөгийг ЭМСалбарын, 0,3 хувийг буюу 7,7 сая төгрөгийг БТСХорооны, 0,7 хувийг буюу 20,6 сая төгрөгийг ГХБХБГазрын бараа материалын үлдэгдэл эзлэж байна.

#### 11.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

ТЗШ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар үндсэн хөрөнгө бүтэц дараах байдалтай байна.

/сая төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	хувь
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>95,857.0</b>	<b>101,224.7</b>	<b>5,367.7</b>	<b>5.3</b>
Биет хөрөнгө	95,803.2	101,158.8	5,355.6	5.3
Биет бус хөрөнгө	53.8	65.9	12.1	22.1

Нийт үндсэн хөрөнгийн 81,6 хувийг барилга байгууламж, 1,1 хувийг тээврийн хэрэгсэл, 5,9 хувийг машин тоног төхөөрөмж, 4,4 хувийг тавилга, эд хогшил, 1,5 хувийг түүх соёл, музейн дурсгалт зүйлс, 3,2 хувийг дуусаагүй барилга, 1.2 хувийг ном, 0.1 хувийг биет бус хөрөнгө, 1,0 хувийг бусад үндсэн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгө оны эхнээс 5,367.7 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд барилга байгууламж 3,536.2 сая төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 59.0 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 283.7 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 146.4 сая төгрөгөөр, ном 36,7 сая, дуусаагүй барилга 1200,0 сая төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө 93.6 сая төгрөгөөр, биет бус хөрөнгө 12,1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын, ОН-ийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болжээ.

#### 11.5 .Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

Тусгай зориулалтын шилжүүлгийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланда нийт өглөг 450,0 сая төгрөгөөр буурч, 262,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Өглөгийн үлдэгдлийг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	хувь
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	712.18	262.16	(450.03)	(63.19)
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	712.18	262.16	(450.03)	(63.19)
<b>Өглөг</b>	712.18	262.16	(450.03)	(63.2)
Ажилчидтай холбогдсон өглөг	86.55	34.22	(52.33)	(60.5)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	132.69	72.93	(59.75)	(45.0)
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	4.85	4.85	
<b>Бусад өглөг</b>	492.94	150.14	(342.79)	(69.5)
Байгууллагад төлөх өглөг	404.12	120.36	(283.76)	(70.2)

Хувь хүмүүст төлөх өглөг	63.55	10.84	(52.71)	(82.9)
Татварын өглөг	5.21	0.00	(5.21)	(100.0)
НДШ - ийн өглөг	13.10	18.94	5.85	44.6

*Богино хугацаат өглөгийг салбараар нь харуулбал дараах байдалтай байна.  
(сая төгрөг)*

	Байгууллагуудын нэр	Эцсийн үлдэгдэл
ЕБСургууль дүн		138.6
СТөв дүн		57.5
Хүүхдийн цэцэрлэг дүн		18.4
ЭМТөв дүн		46.8
ГХБХБГазар		0,8
<b>Нийт дүн</b>		<b>262.2</b>

ЕБСургууль 138,7 сая төгрөгийгийн, Соёлын байгууллага 57,5 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 18,4 сая төгрөгийн, ЭМТөв 46,8 сая төгрөгийн, ГХБХБГазар 0,8 сая төгрөгийн өглөгтэй байна.

## 11.6 Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт

Тусгай зориулалтын шилжүүлгийг байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

(сая.төгрөгөөр)

Үзүүлэлт	Нийт дүн	БСШУ-ын сайд	ХАХНХ-ын сайд	БХБСайд	ЭМС-ын сайд
Батлагдсан төсөв	46382,9	42091,5	98,4	262,2	3930,8
Олгосон урсгал санхүүжилт	46203,0	41917,1	98,3	261,5	3926,1
Нийт төвлөрүүлсэн	126,1	121,4			4,7
Үүнээс: Төсөвт /Сангийн яам/	126,1	121,4			4,7
Өглөгт тооцсон	-	-	-	-	-

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлэгт 46382,0 сая төгрөгийн төсөв батлагдаж, 46203,0 сая төгрөгийг олгож, 126,1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

## Арван хоёр. Орон нутгийн хөрөнгө оруулалтын талаар

### 12.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Аймгийн ИТХ-ын 2016 оны 71 тоот тогтоолоор 2015 оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс санхүүжүүлэн 2016 онд хэрэгжүүлэхээр 854,7 сая төгрөгийн өртөг бүхий 26 төсөл арга хэмжээг, ирэх онд хэрэгжих ТАХ-ний зураг төсвийн зардал, тусламжийн хөрөнгийн тээврийн зардал, гадаадын тусламжаар хэрэгжих төсөл арга хэмжээний орон нутгийн оролцоо зэрэг зардуудад 151,4 сая төгрөг нийтдээ 1006,1 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын чиглэлээр зарцуулахаар төсөв батлагдсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын Төрийн сан дахь данснаас 827,6 сая төгрөгийг хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтээр олгож, 137,1 сая төгрөгийг

батлагдсан төсвийн дагуу бусад зардалд зарцуулж, оны эцэст дансны үлдэгдэл 41,8 сая төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.Олгосон санхүүжилт:

а.2016 онд БСШУСайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтын дагуу 841.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн.

б. ЭМСайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтын данснаас 2016 онд нийтдээ 267,7 сая төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулсан.

в. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрх шилжүүлсэний дагуу 49,3 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэний дагуу нийтдээ 1158,8 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч компаниудад ажлын гүйцэтгэлээр олгожээ.

## 12.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт

Аймгийн ИТХурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн XVI дугаар хуралдааны 63 тоот тогтоолоор Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийн нийт дүнг 4018.0 сая төгрөгөөр баталжээ.Үүнээс сумдын ОНХСанд 2009.0 сая төгрөгийн, аймгийн ОНХСанд 2009.0 сая төгрөгийн хөрөнгийг хуваарилсан байна.

Төсвийн тодотголоор ОНХСангаас авах орлогын шилжүүлгийг 3278.1 сая төгрөгөөр баталж, аймгийн 2015 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс 127.4 сая төгрөгийг, бусад орлогоос 152.6 сая төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, ОНХСангийн орлогын нийт дүнг 3558.1 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь анх батлагдсан төсвөөс 459.9 сая төгрөөр буюу 11.4 хувиар буурсан байна.Үүнээс сумын ОНХСанд 1726.6 сая төгрөгийн, аймгийн ОНХСанд 1831.5 сая төгрөгийн хөрөнгийг олгохоор хуваарилсан байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Тодотгосон төлөвлөгөө
ОНХНэгдсэн сангаас хуваарилах орлого	<b>3278.1</b>
Аймгийн 2015 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс хуваарилсан хөрөнгө	127.4
Аж ахуйн нэгж, байгууллагад олгосон санхүүжилтийг буцаан төлүүлсний орлого	152.6
<b>Нийт дүн</b>	<b>3558.1</b>
<b>Үүнээс:</b> Сумдын ОНХСанд олгох орлогын шилжүүлэг	1726.6
Аймгийн ОНХСанд олгох орлогын шилжүүлэг	1831.5

ОНХ сангийн орлогын бүрдүүлэлт, олголтын байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.Үүнд:

Санхүүжилтийн эх үүсвэр	Тодотгосон төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төг/
ОНХСангийн 2015 оны жилийн эцсийн үлдэгдэл	127.4	127.4	
Орлого		3412.7	

ОНХНэгдсэн сангаас хуваарилагдсан хөрөнгө	3278.1	3260.1
2015 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс	9.9	9.9
ААНбайгууллагад илүү олгосон санхүүжилтийг буцаан төлүүлсний орлого	29.6	29.6
Цэнгэл сумын төсөлд эргэж төлөгдөх нөхцлөөр олгосон хөрөнгө	80.0	80.0
БНХАУлсын Алтай аймгаас олгосон хандив	30.0	30.0
Бусад	3.1	3.1
<b>ОНХСангийн нийт эх үүсвэр</b>	<b>3558.1</b>	<b>3540.1</b>
Сумын ОНХСанд хуваарилсан орлогын шилжүүлэг	1726.6	1280.1
Аймгийн ОНХСанд хуваарилсан орлогын шилжүүлэг	1831.5	1829.5
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>430.0</b>	

ОНХ сангийн 2015 оны жилийн эцсийн үлдэгдэл нь 127,4 сая төгрөг ба 3412,7 сая төгрөгийг орлогыг оруулж, аймгийн болон сумын ОНХ санд 3109,6 сая төгрөгийг хуваарилан олгож, 2016 оны жилийн эцэст 430,0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө үлдсэн байна.

### **Арван гурав. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар**

Аймгийн аудитын газраас төсвийн байгууллага, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийх баталгаажуулах аудитын төлөвлөгөөнд төсвийн шууд захирагч 39, аж ахуйн нэгж 3, төвлөрүүлэн захирагч 14, төсвийн ерөнхийлөн захирагч 1 бүгд 57 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргахаар, 168 төсвийн шууд шахирагч, төсөл сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулахаар төлөвлөж, 27 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж өнжөөхөөр тусгагдсан.

Үүнээс Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүнд ордог төсвийн шууд захирагч 20, аж ахуйн нэгж 3, төвлөрүүлэн захирагч 14, төсвийн ерөнхийлөн захирагч 1 бүгд 38 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргахаар, 168 төсвийн шууд шахирагч, төсөл сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулахаар төлөвлөж, 9 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж өнжөөсөн болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн харьяа байгууллагуудаас нийтдээ 2085,9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч үүнээс 1788,4 сая төгрөгийн алдаа зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийж, 63,8 сая төгрөгийн зөрчил төлбөрийн акт тогтоож, 40,7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 190,0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 14 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

Аудитаар илэрсэн нийт алдаа зөрчлийн 92,5 хувийг нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой алдаа зөрчлүүд эзэлж байна. Мөн нийт алдаа зөрчлийн 2058,3 сая төгрөгийг буюу 98,7 хувийг төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа зөрчил эзэлж байгаа бөгөөд үүнээс 383,0 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлантай холбоотой, 1675,2 сая төгрөг нь сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой алдаа зөрчил байна.

Аудитын дүнгээр 38 санал дүгнэлт гаргасан ба үүнээс 33 санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт, 4 санхүүгийн тайланд нь хязгаарлалттай санал дүгнэлт өгч 1 байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан хариу өгөв.

Орон нутгийн өмчийн газар болон Дэлүүн, Улаанхус сум, Цагааннуур тосгоны ТТЗ-ийн СНТайлангаас илэрсэн алдаа зөчрлийн дүн материаллаг түвшингээс их дүнтэй, зөрчлийн шинж байдлыг харгалзан хязгаарлалттай санал дүгнэлт өгөв. Харин Өлгий сумын ЗДТГазар нь санхүүгийн тайлангаа хуулинд заасан хугацаанаас хожимдуулан ирүүлсэний дээр аудитын дүгнэлт гаргахад шаардлагатай санхүүгийн баримт материалуудыг гаргаж ирүүлээгүйгээс дүгнэлт гаргах боломжгүй болж, дүгнэлт өгөхөөс татгалзсан хариу өгөв.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн хувьд 18 байгууллагад зөрчилгүй, 1 байгууллагад хязгаарлалттай, 1 байгууллагын тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзсан.

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн хувьд 11 ТТЗ-ийн СНТайланд зөрчилгүй санал дүгнэлт, 3 ТТЗ-ийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгөв.

Аудитын явцад хийсэн сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн зарим батламж мэдэгдэлтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчлүүд илэрсэн нь зарим тайланд өгөх санал дүгнэлтийг хязгаарлахад хүргэлээ. Үүнд:

#### **“Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:**

№	“Хязгаарлалттай” санал, дүгнэлт авсан байгууллага	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Орон нутгийн өмчийн газар	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн тайланг нийт дунгээр 18,2 сая төгрөгийн алдаатай гаргаж ирүүлж, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан журмыг зөрчсөн.</li> </ul>
2	Дэлүүн сумын ТТЗ-ийн СНТ	<ul style="list-style-type: none"> <li>Нэгтгэсэн санхүүгийн тайланг 104,5 сая төгрөгийн алдаатай гаргаж Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам” болон Төсвийн тухай хуулийн 26.1 дэх заалтыг зөрчсөн. 2016 орон нутгийн төсвийн орлогыг 20,9 сая төгрөгөөр тасалдуулж Төсвийн тухай хуулийн 41.2.1-т заасан “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн.</li> </ul>
3	Улаанхус сумын ТТЗ-ийн СНТ	<ul style="list-style-type: none"> <li>Нэгтгэсэн санхүүгийн тайланг 323,9 сая төгрөгийн алдаатай гаргаж Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам” болон Төсвийн тухай хуулийн 26.1 дэх заалтыг зөрчсөн.</li> </ul>
4	Цагааннуур тосгоны ТТЗ-ийн СНТ	<ul style="list-style-type: none"> <li>Нэгтгэсэн санхүүгийн тайланг 452,6 сая төгрөгийн алдаатай гаргаж Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам” болон Төсвийн тухай хуулийн 26.1 дэх заалтыг зөрчсөн.</li> </ul>
5		<ul style="list-style-type: none"> <li></li> </ul>

#### **“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:**

№	“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” байгууллага	“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” шалтгаан
1	Өлгий сумын ЗДТГ	<ul style="list-style-type: none"> <li>Өлгий сумын ЗДТГазар санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанаас хожимдуулан ирүүлсэний дээр аудитын дүгнэлт гаргахад шаардлагатай санхүүгийн баримт материалуудыг гаргаж ирүүлээгүйгээс санал дүгнэлт өгөхөөс татгалзав.</li> </ul>

## Арван дөрөв. Өмнөх оны аудитын зөвлөмжийн талаар

ТЕЗ-ийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 заалт бүхий зөвлөмж өгөгдсөний 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж 2 зөвлөмжийнг хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна .Үүнд:

1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, тэмдэглэлийг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу дэлгэрэнгүй бэлтгэж ирүүлж байх;

2.Төсвийн тухай хуулийн 26.1-д заасан "Төсвийн байгууллага нь нягтлан бodoх бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бodoх бүртгэл хөтлөнө" гэсэн заалтыг хэрэгжүүлж Төсвийн байгууллагуудад хэрэглэх нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдүүлэх ажлыг хийж, хэрэгжүүлэх, УСНББОУС-ыг бүрэн нэвтрүүлэх, сумын санхүүгийн алба, нягтлан бодогч нарыг мэргэжлийн арга зүйгээр хангаж, мэргэжил ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

### Арван тав. Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт

Аудитаар ТЕЗ-ийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, төсвийн байгууллагад мөрдөж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горимуудаар олж авсан нотлох зүйлс, шалган тооцоолсон дүнг үндэслэн Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах алдаа зөрүүнүүд нь Оршин байх, Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.Үүнд:

- Нийт хөрөнгө, өр төлбөр/цэвэр хөрөнгийн эцсийн үлдэгдэл аудитлагдсан дүнгээс 50,8 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн.
- Үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн аудитлагдсан дүнгээс 20,200.6 сая төгрөгөөр, Мөнгөн гүйлгээний нийт орлогын дүн 20,072.1 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлэгдсэн.
- Үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн аудитлагдсан дүнгээс 19,829.5 сая төгрөгөөр илүү, үр дүн 11.7 сая төгрөгөөр зөрүүтэй, мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлагын дүн аудитлагдсан дүнгээс 19,213.5 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна.

Дээрхи зөрүүнүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгдсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

## Арван зургаа. Аудитын зөвлөмж

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аudit бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидалын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баян-Өлгий аймгийн Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аudit хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.Үүнд:

### Аймгийн Засаг дарга А.Гылымхан танаа:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.4-т заасан хугацаанд, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу алдаагүй нэгтгэн гаргаж, дэлгэрэнгүй тайлбар тодруулгын хамт бэлтгэж ирүүлж байх, ТЕЗ-ийн СНТайлангийн аудитаар гарсан зөрүүнүүдийг е-тайлан программаас дахин хянаж арилгах;
2. Төсөвт байгууллага, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн Засгийн газрын е-тайлан цахим системд аудитлагдсан санхүүгийн тайланг алдаагүй, үнэн зөв шивж оруулсан эсэхийг сумын санхүүгийн алба болон аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн зүгээс давхар хянан баталгаажуулж, илэрсэн алдаа зөрчлийг тухай бүрт нь арилгаж ажиллах;
3. Төсвийн тухай хуулийн 26.1-д заасан "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтлөнө" гэсэн заалтыг хэрэгжүүлж Төсвийн байгууллагуудад хэрэглэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдүүлэх ажлыг хийж, хэрэгжүүлэх, УСНББОУС-ыг бүрэн нэвтрүүлэх, сумын санхүүгийн алба, нягтлан бодогч нарыг мэргэжлийн арга зүйгээр хангаж, мэргэжил үр чадварыг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах;

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

М.АЙНУР

АУДИТОР

Д.НАЗГУЛ

АУДИТОР

Х.МАНАРГУЛ

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА

2017.4.20